



НИЙГМИЙН ДААТГАЛЫН ҮНДЭСНИЙ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

2024 оны 11 сарын 08 өдөр

Дугаар 12.

Улаанбаатар хот

Урамшууллын хэмжээг тогтоох тухай

Нийгмийн даатгалын ерөнхий хуулийн 13 дугаар зүйлийн 13.3, 13.7 дахь хэсэг, Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн 2024 оны 03 дугаар тогтоолоор баталсан олон нийтийн хяналтын зөвлөлийн дүрмийн 6 дугаар зүйлийн 6.4, 6.5 дахь хэсгийг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1.Нийгмийн даатгалын сангийн чөлөөт мөнгөн хөрөнгийг санхүүгийн хэрэгсэлд оруулах үйл ажиллагаанд хяналт тавих чиг үүрэг бүхий олон нийтийн хяналтын зөвлөлийн гишүүнд олгох урамшууллын хэмжээг эрх бүхий байгууллагаас тогтоосон сарын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээгээр сар бүр тооцож, улирал тутам олгож байхаар тогтоосугай.

2.Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн ажлын алба (Г.Банзрагч)-нд даалгасугай.

ДАРГА



Д.ЭНХ-АМГАЛАН